

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР  Г.АНХЖАРГАЛ

**8 ДУГААР АНГИЙН “МОНГОЛ ХЭЛ БИЧИГ” ХИЧЭЭЛИЙН
ШАЛГАЛТ- ХУВИЛБАР – А**

Төв Азийн минж

Минж өөрийн амьдрах орчиндоо амрах хэвтэх, муу нүх, овоохой, далан зэрэг хэд хэдэн төрлийн хоргодох байрыг бий болгодог. Голын гүн устай, өндөр эрэгтэй газар нүх ухаж овоохой засна. Нүхний ам усны гүнд. Нүхэнд агаар оруулах салхивч өрхтэй. Овоохойн хэмжээ бүлийн тооноос хамаарч харилцан адилгүй байна. Нэг бүлд эр, эмэгчин тухайн жилийн үр төл хамт амьдарна. Эзэмшил нутгийнхаа захад шороо овоолон заагаараа тэмдэг тавина.

Овоохойн урт өргөн 6*4 метр орчим, өндөр нэг метр, ханын зузаан 20-30 см орчим хэмжээтэй байна. Овоохойг бүдүүвтэр мод босгон модны мөчир болон бусад ургамлын иш мөчрөөр барьж, шавардаж нягтруулсаар бат бэх болгосон байдаг. Даланг голдуу ус багатай жижгэвтэр голд барих бөгөөд хамгийн хялбар далан гэхэд л 1-2 метр урттай байна. Далан гэж минжнүүд голын урсгал, салаа, татуургад бүдүүн мод, модны мөчрүүдийг богинохон мэрж таслан усны урсгалд хөндөлдүүлэн, давхарлан овоолж, гарсан зай завсрыг голын шавар, мод, чулуугаар бэхжүүлж барьсан зүйлийг хэлнэ.

Минж бол өвсөн тэжээлтэн. Бургас, улиас, улиангар зэрэг модлог ургамлууд, улалж, цагаан бөмбөө, жагмаа зэгс зэрэг усны ургамлууд, нийт 300 гаруй зүйлийн модлог болон өвслөг ургамлаар хооллодог.

Эх дээр гүйцэтгэх даалгавар:

1. Эхийн гол санааг 40-50 үгэнд тайлбарла
Үг хэллэгийн утга тайлбарла
 - Овоохой
 - далан
2. Эхээс үйлийн холбох нөхцөлтэй үйл үгийг түүвэрлэж бич.
3. Дараах үгийг бүтцээр задлан зөв бичих дүрмийг тайлбарла.
Таслан
4. Өгсөн үгсэд урт эгшгээр эхэлсэн залгавар залгаж бичээд дүгнэлт гаргана уу.
Дорнодын
5. Дараах нийлмэл өгүүлбэрээс учир шалтгааны утгатай өгүүлбэрийг ялгана уу.
Хялмаа ихэдвэл зуд болно
Хялар ихэдвэл сохор болно.

Уран зохиол

6. “Гэрийн ерөөл” -д буй Төвөд үгсийн бэлгэдэл нь юу болохыг бичээрэй.
Хорол-.....
Норов-
Нацаг-.....
Бадмаанямбуу -
7. Монгол бичиг Галигийг үндэсний бичигт хөрвүүлнэ үү.
Тэрэ-бэр жиргал зобаланг-ун жим-а-йи зориг жирүхэ-бэр-ийэн тугулба.
Тэмэгэ гэвэл имаг-а гэхү, тэбэнэ гэвэл зэгүү гэхү.

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР **БАТЛАВ** ГАНХЖАРГАЛ

**8 ДУГААР АНГИЙН “МОНГОЛ ХЭЛ БИЧИГ” ХИЧЭЭЛИЙН
ШАЛГАЛТ- ХУВИЛБАР – Б**

Өвөл

Би номын мөр хөөж, хот суурин газар анхны цасыг угтаж, сүүлчийн цасыг үдэх боллоо. Энд анхны цас жигтэй түргэн хайлах юм. Өвөл гэсэн ондоо, хот газрын өвөл болно. Тэнгэр гэдэг цастай цонх шиг цэвцийн цайрч, нар гэдэг сонингоор халхалсан чийдэн шиг зузаан үүлэн цаана тэмдэг төдий сүүмийнэ. Унадаг дугуй, бүсгүйчүүдийн үзэсгэлэн намрын шувуудтай буцчихсан юм шиг гудамж талбайд үзэгдэх нь ховордоно. Өдөржин гадаа байдаг багачуул голцуу л гал тогооны өрөөнд хөгшин эмгэдийн хамт өнжинө. Шувуу буцаад, жигүүртэн ховордоод тэр үү тагтаа болжмор хоёрыг цонхоор ажиглах болов. Хааяа нэг тохиолдох нам гүм, цас мөс гялалзсан өдөр тагтаа сүрэглэн тэнгэрт гарч, элин халин сэтгэлийн чилээ гарган, инээж баясаж байх шиг харагдана. Тувт дулаан байранд бүгэн суусаар хамаг биед байшин барилгын үнэр нэвччихсэн юм шиг бодогдоно. Хөдөөнөөс ирсэн хүнээс жавар ханхлах сайхан санагдана.

Жихүүн салхи ганц нэгээр уйтгартай нь аргагүй исгэрч, цас манарган одно. Хаа нэг дайралдах малын мөр дулаан харагдана. Малын мөр олшрохоор сэтгэл онгойно. Удалгүй утаа үнэртэн, өвөлжөөний зүг цувсан малын зөрөг харагдаж нохой хуцна. /Д.Батбаяр/

Эх дээр гүйцэтгэх даалгавар:

1. Эхийн гол санааг 20-30 үгэнд тайлбарла.
 2. Үг хэллэгийн утга тайлбарла.
 - Зөрөг
 - элин халин
 3. Эхээс үйл үг үүсгэх дагавартай үгийг түүвэрлэж бич
 4. Дараах үгийг бүтцээр задлан зөв бичих дүрмийг тайлбарла.
 - тэнгэрийн
 5. Учир шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгон задалж бизэрэй.
Долоо хоногийн махны хэрэглээ 600 граммаас илүүгүй байх нь зохимжтой, учир нь мах биемахбодод төмөр, эрдэс бодис, амин дэм өгдөг.
- Уран зохиол
6. “Гэрийн ерөөл”-д хаалгыг хэрхэн дүрсэлж бичсэн бэ?
 7. Монгол бичиг Галигийг үндэсний бичигт хөрвүүлнэ үү.
Монгол бангхур бол монгол хүмүн-ү үлү урбаху нөхөр йум. Монгол бангхур-ун хоголай боргил, бэй-э бахим, хөл майиг-а.

.....
.....
.....
.....